

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН 20.... ОНЫ НЭГДСЭН ТАЙЛАНГИЙН МАЯГТ (3-ОУИТБС-5)НӨХӨХ  
ЗААВАР**

Ашигт малтмал, Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тусдаа ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгж бүрээр, үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, тусгай зөвшөөрлийн үндсэн мэдээллийн тайланг дараа оны 5 дугаар сарын 15-ны дотор гаргаж ОУИТБС-ын Цахим тайлагналын системээр ирүүлнэ.

**I.1 БАЙГУУЛЛАГЫН ХАЯГИЙН ХЭСЭГ**

Аж ахуйн нэгж, байгууллагын хаягийг албан ёсны нэрийн хамт нөхнө.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэлийг үнэн зөв нөхнө.

**I.2 АЖ АХУЙН НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ**

Ашигт малтмалын хайгуул, газрын тосны олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн нэр, регистрийг нөхнө.

**II. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

**1. АШИГЛАЛТ БОЛОН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

Тусгай зөвшөөрөл / бүтээгдэхүүн хуваах гэрээний мэдээллийг ашигт малтмалын нэр төрөл бүрээр гаргах бөгөөд тусгай зөвшөөрөл / бүтээгдэхүүн хуваах гэрээний мэдээлэлд үндэслэн нөхнө. Багана 3-д тухайн ашигт малтмалын ордын оршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг болон газрын нэрийг тодорхой бичнэ. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хувьд хайж байгаа ашигт малтмалын нэр, талбайн хэмжээ, олгосон огноо, ордын оршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг болон газрын нэрийг нөхнө.

**2. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЛБОРЛОЛТ, БОРЛУУЛАЛТ**

**2.1 ТУРШИЛТ/ХАЙГУУЛЫН ҮЕИЙН ОЛБОРЛОЛТ, БОРЛУУЛАЛТ**

Тайлант жилд хайгуулын тусгай зөвшөөрлийн дагуу туршилтын журмаар олборлосон болон борлуулсан бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нөхнө. Олборлолт, борлуулалтын биет хэмжээгээр багана 1, 2-т, мөнгөн дүнгээр багана 3, 4-т нөхнө. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг үнийн дүнгээр гаргахдаа үйлдвэрлэгчийн өртгөөр нь харин борлуулалтыг гаргахдаа худалдан авагчийн үнээр бодож нөхнө. 5 дугаар баганад туршилтын хугацаанд дотоодод борлуулсан хэмжээг биетээр, 6 дугаар баганад орлогыг мөнгөн дүнгээр нөхнө. 7 дугаар баганад туршилтын хугацаанд экспортолсон биет хэмжээг, 8 дугаар баганад экспортын хэмжээг мөнгөн дүнгээр нөхнө. 9 дүгээр баганад нийт борлуулалтын биет хэмжээг, 10 дугаар баганад нийт борлуулалтын мөнгөн дүнг нөхнө.

**2.2 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ**

Тайлант жилд олборлосон болон борлуулсан бүтээгдэхүүний нэр төрлөөр нөхнө. Олборлолт, борлуулалтыг биет хэмжээгээр багана 1-т, үнийн дүнгээр багана 2-т нөхнө.

3 дугаар баганад дотоодод борлуулсан хэмжээг биетээр, 4 дугаар баганад орлогыг мөнгөн дүнгээр нөхнө. 5 дугаар баганад экспортолсон биет хэмжээг, 6 дугаар баганад экспортын хэмжээг мөнгөн дүнгээр нөхнө. 7 дүгээр баганад нийт борлуулалтын биет хэмжээг, 8 дугаар баганад нийт борлуулалтын мөнгөн дүнг нөхнө.

Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг үнийн дүнгээр гаргахдаа үйлдвэрлэгчийн өртгөөр, харин борлуулалтыг гаргахдаа худалдан авагчийн үнээр гаргана. Бүтээгдэхүүний кодыг дараах хүснэгтээс харж нөхнө.

**БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН АНГИЛАЛ**

Код	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Код	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж
-----	--------------------	-------------	-----	--------------------	-------------

1101000	Чулуун нүүрс	мян.т	1429041	Цагаан тугалганы хүдэр	мян.тонн
1102000	Брикет, шахмал нүүрс	мян.т	1429042	Цагаан тугалганы баяжмал	тонн
1103000	Хүрэн нүүрс	мян.т	1429051	Хар тугалгын хүдэр	мян.тонн
1105000	Хүлэр	мян.т	1429052	Хар тугалгын баяжмал	мян.тонн
1201000	Газрын тос	барр.	1429090	Бусад төрлийн хүдэр ба баяжмал	мян.тонн
<b>Код</b>	<b>Бүтээгдэхүүний нэр</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Код</b>	<b>Бүтээгдэхүүний нэр</b>	<b>Хэмжих нэгж</b>
1202000	Байгалийн хий (хий болон шингэн)	мян.м3	1512010	Гантиг	мян.м3
1203000	Байгалийн битүм, шатдаг занар, тослог элс	тонн	1512020	Барилгын шохойжсон чулуу	мян.м3
1300000	Уран болон торийн хүдэр, тэдгээрийн баяжмал	тонн	1513010	Боржин	мян.м3
1410000	Төмрийн хүдэр	мян.тонн	1513020	Хөшөөний чулуу	мян.м3
1410001	Төмрийн хүдэр баяжмал	мян.тонн	1513030	Үерийн чулуу	мян.м3
1421010	Зэсийн хүдэр	тонн	1513090	Гантиг, барилгын шохойжсон бусад төрлийн чулуу	мян.м3
1421020	Зэсийн баяжмал, металл агуулгаараа	тонн	1531000	Шохойн чулуу	мян.тонн
1422000	Никелийн хүдэр, баяжмал	тонн	1532010	Байгалийн элс	мян.м3
1423000	Хөнгөн цагааны хүдэр, баяжмал	мян.тонн	1532020	Буталмал чулуу	мян.м3
1424010	Мөнгөний хүдэр	кг	1532030	Хайрга, шороо	мян.м3
1424020	Мөнгөний баяжмал	кг	1533000	Дайрга	мян.м3
1424040	Алт	кг	1540000	Байгалийн лав (битум), цардас (асфальт), цардас	тонн
1429011	Цайрын хүдэр	мян.тонн	1612000	Шавар	мян.м3
1429012	Цайрын баяжмал	мян.тонн	1619010	Хайлуулаагүй төмрийн пирит	тонн
1429021	Гянтболд/вольфрамын хүдэр	тонн	1619020	Хайлуур жонш	мян.тонн
1429022	Гянтболд/вольфрамын баяжмал	тонн	1620090	Хайлуур жоншны баяжмал	мян.тонн
1429031	Молибдений хүдэр	мян.тонн	1633000	Давс	мян.тн
1429032	Молибдений баяжмал, металл агуулгаараа	мян.тонн	1531000	Шохой болон гөлтгөнө (доломит)	мян.тн
1511000	Занар	тонн	3754012	Тоосго	мян.ш

### 3. ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТ, БОРЛУУЛАЛТ

Газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгж бүр олборлолт, борлуулалт, үүнээс засгийн газарт ногдох хэмжээг гэрээт талбай тус бүрээр тайлагнана. Багана 1, 3, 5-д олборлосон газрын тосны хэмжээг баррелиар, багана 2-д олборлолтын өртгийг 4, 6-д борлуулсан үнийн дүнг мэдээлнэ. 7, 8 дугаар баганад гадаадад экспортлосон болон дотоодод боруулсан хэмжээг баррелиар, 8, 10 дугаар баганад гадаадад экспортлосон болон дотоодод борлуулсан хэмжээг үнийн дүнгээр тайлагнана.

**МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН АЖЛЫН АЛБАУТАС:**

**(976)-70110525, ФАКС: (976)-70110155**